

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/041/НА-СТА-ОНТС

Цахим хуудас: www.audit.mn

Улаангом хот

2026 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Т.Золоо

Утас: 70453799, Цахим хаяг: Zoloot@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
4. Аудитын тайлан	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. Аудитын илрүүлэлт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Д.БАЯРМАА ТАНАА

2026.03.12 № УВА-2026/0411/НӨ-СТА-ОНТС
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Увс аймгийн Нийгмийн халамжийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Нийгмийн халамжийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

8525050664

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/	
		1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	352,500.00	-
33	1.1.3 АВЛАГА	352,500.00	-
33500	1.1.3.07 Бусад авлага	352,500.00	-
33510	1.1.3.07.01 Байгууллагаас авах авлага	352,500.00	-
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	352,500.00	-
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	352,500.00	-
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	352,500.00	-
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	352,500.00	-
51210	2.2.1.08.01 Өмнөх үеийн үр дүн	-	352,500.00
51220	2.2.1.08.02 Тайлант үеийн үр дүн	352,500.00	(352,500.00)
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	352,500.00	-

2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/	
		1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	188,106,700.00	491,406,800.00
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	491,406,800.00
122	1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	491,406,800.00
1221	1.1.1.04.3.0 Хандив тусламж /дотоод/	-	491,406,800.00
12211	1.1.1.04.3.01.01 Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	491,406,800.00
122111	1.1.1.04.3.01.01.1 Урсгал санхүүжилтийн орлого\	-	491,406,800.00
13	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	188,106,700.00	-
1320	1.1.1.05.3 Орон нутгийн төсвөөс санхүүжих	188,106,700.00	-
132001	1.1.1.05.3.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	188,106,700.00	-
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	187,754,200.00	491,759,300.00
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	187,754,200.00	491,759,300.00
213	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187,754,200.00	491,759,300.00

2131	1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	161,279,657.00
21311	1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	161,279,657.00
213112	1.1.2.01.4.01.01.2 Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	161,279,657.00
2131121	1.1.2.01.4.01.01.2.1 Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\)	-	161,279,657.00
2132	1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	187,745,000.00	330,479,643.00
213203	1.1.2.01.4.02.02 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	187,745,000.00	330,479,643.00
2134	1.1.2.01.4.04 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,200.00	-
213403	1.1.2.01.4.04.03 Төвлөрүүлэх шилжүүлэг	9,200.00	-
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	352,500.00	(352,500.00)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	352,500.00	(352,500.00)

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	/төгрөгөөр/	
		1. Өмнөх он	2. Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	188,106,700	491,759,300
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	491,759,300
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	-	352,500
120009	1.1.1.1.04.1.09 Бусад орлого	-	352,500
122	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	491,406,800
1221	1.1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	-	491,406,800
12211	1.1.1.1.04.3.01.01 Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	491,406,800
122111	1.1.1.1.04.3.01.01.1 Урсгал санхүүжилтийн орлого\	-	491,406,800
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	188,106,700	-
1320	1.1.1.1.05.3 Орон нутгийн төсвөөс санхүүжих	188,106,700	-
132001	1.1.1.1.05.3.01 Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	188,106,700	-
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	188,106,700	491,759,300
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	188,106,700	491,759,300
213	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	188,106,700	491,759,300
2131	1.1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	161,279,657
21311	1.1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	161,279,657

213112	1.1.1.2.01.4.01.01.2 Төсвийн байгууллагаас харьяа төрийн сан руу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	161,279,657
2131121	1.1.1.2.01.4.01.01.2.1 Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	161,279,657
2132	1.1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	188,097,500	330,479,643
213203	1.1.1.2.01.4.02.02 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	188,097,500	330,479,643
2134	1.1.1.2.01.4.04 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	9,200	-
213403	1.1.1.2.01.4.04.03 Төвлөрүүлэх шилжүүлэг	9,200	-
III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	-
VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	0	0	352,500.00	352,500.00
10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	352,500.00	352,500.00
11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	352,500.00	352,500.00
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	352,500.00	352,500.00
19	1.7 Тайлант үеийн үр дүн	0	0	-352,500.00	-352,500.00

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	491,407,600	330,479,643
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	491,407,600	330,479,643
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	-	352,500
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	-	352,500
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	491,407,600	330,127,143
122005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	491,407,600	330,127,143

II	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	491,407,600	330,479,643
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	491,407,600	330,479,643
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	491,407,600	330,479,643
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	491,407,600	330,479,643
213203	3.1.01.2.1.4.2.02 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	491,407,600	330,479,643
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-
7	3. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Нийгмийн халамжийн сангийн нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн халамж үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх чиглэлээр ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
- Ахмад насны тухай хууль
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх журам
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийгмийн халамжийн сан бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/53 дугаар тушаал “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний аргачлал, заавар, үйлчилгээний үнэ тариф, гэрээний загвар батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 352.5 мянган төгрөгөөр буюу 352.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	352.5	0	-352.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал			
Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө	352.5	0.0	-352.5
Өр төлбөр		0.0	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	352.5	0.0	-352.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	352.5	0.0	-352.5

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 352.5 мянган төгрөг болж буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 549,430.0 мянга, нийт зарлагыг 549,430.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвөөс 56,849.2 мянган төгрөгөөр бууруулж 492,580.8 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,173.2 мянган төгрөгөөр бууруулж 491,407.6 мянган төгрөгөөр тодотгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 330,479.6 мянган төгрөг буюу 67.2 хувийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Орон нутаг /71902-80708/	70,106.8	69,600.0	0.5	99.9%
2	Орон нутаг /71902-80709/	421,300.8	260,879.6	160.421.2	61.9%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. 2024 онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого зарлагын гүйлгээ гараагүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх 8 тендер цахим хэлбэрээр зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Нийгмийн халамжийн сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Золоо гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 187,754.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,880.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 492,111.8 мянган төгрөгийн 1 хувиар 4,921.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 3,936.9 мянган төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Увс аймгийн Нийгмийн халамжийн сангийн төсөв захирагчийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн халамжийн сан нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 154 мэдээллээс хугацаандаа оруулсан 152, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 16 удаагийн мөнгөн гүйлгээ 407,252.5 мянган төгрөгийн мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, 6 удаагийн мөнгөн гүйлгээ 84,506.8 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 15 удаагийн мөнгөн гүйлгээ 260,879.6 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 75,600.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй гэж дүгнэж зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Нийгмийн халамжийн сангийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 650,228.6 мянган төгрөгийн алдаа илэрснээс 70,459.3 мянган төгрөгийн алдааг зарлуулж, 579,769.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

5.1 Залруулга

Увс аймгийн Нийгмийн халамжийн сан нь мөнгөн гүйлгээний тайланд нийт зарлагын дүнг 70,106.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан, санхүүгийн үр дүнгийн тайланд 352.5 мянган төгрөгийн тусгаагүй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 14.4 дэх заалт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалт “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

5.2 Зөвлөмж

1. Илрүүлэлт

Увс аймгийн халамжийн сан нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 154 мэдээллээс хугацаандаа оруулсан 152, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 14 удаагийн мөнгөн гүйлгээ 376,652.5 мянган төгрөгийн мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан, 6 удаагийн мөнгөн гүйлгээ 84,506.8 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 2 удаагийн мөнгөн гүйлгээ 23,810.0 мянган төгрөгийн мэдээлэл байршуулаагүй, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэлийн 45,000.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 12,000.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг байршуулаагүй, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал 37,800.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл байршуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт”, 6.3.3 дахь заалтад “төсөв хэмнэсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар”, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг 7 хоног дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь заалтад “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мян.төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
санхүүгийн үр дүнгийн тайланд бусад орлогыг тусгаагүй							1	352.5				
Санхүүжилтийн дүнг мөнгөн гүйлгээний тайланд дутуу тусгасан							1	70,106.8				
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	2	70,459.3	0	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроосон мөн байршуулаагүй	1	579,769.3					1	579,769.3
Дүн	1	579,769.3	0	0.0			1	579,769.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Нийт дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



2026 оны 03 сарын 12-ны өдөр